




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 II



www.1212.mn



Улаанбаатар хот
2025 он

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).


II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ¹ дахин












III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

| | |
|--------------------|-------------------------------------|
| мянга | =1000 |
| сая | =10 ⁶ |
| тэрбум | =10 ⁹ |
| их наяд | =10 ¹² |
| мян | мянга |
| % | хувь |
| мм | миллиметр |
| см | сантиметр |
| дм | дециметр |
| м | метр |
| км | километр |
| м ² | метр квадрат |
| дм ² | дециметр квадрат |
| км ² | километр квадрат |
| м ³ | метр куб |
| га | гектар |
| мл | миллилитр |
| л | литр |
| г | грамм |
| кг | килограмм |
| цн | центнер |
| т | тонн |
| Вт | ватт |
| кВт.ц | киловатт цаг |
| кал | калори |
| ккал | килокалори |
| Гкал | гигакалори(=10 ⁹ калори) |
| с | секунд |
| мин | минут |
| мкг/м ³ | микрограмм метр куб |
| м/с | метр секунд |
| ш | ширхэг |
| х.д.х | хэвлэлийн даралтат хуудас |



ГАРЧИГ

| | | |
|---|---|----|
|  | ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2025 ОН | 1 |
|  | ЭРҮҮЛ МЭНД | 2 |
|  | НИЙГМИЙН ДААТГАЛ | 6 |
|  | НИЙГМИЙН ХАЛАМЖ | 10 |
|  | ГЭМТ ХЭРЭГ | 12 |
|  | ДҮҮРГИЙН ТӨСӨВ | 17 |
|  | ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 21 |
|  | ХӨДӨӨ АЖ АХУЙ | 27 |
|  | АЖ ҮЙЛДВЭР | 29 |
|  | ЦАГ УУР, АГААРЫН БОХИРДОЛ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ | 33 |
|  | ЗАХИРГААНЫ МЭДЭЭ | 36 |

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 2 дугаар сар

| Үзүүлэлтүүд | | Хэмжих нэгж | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|--|--------------|-------------|---------------------------|---------------------------|---------------------------|-----------------------------|---------------------------|
| Шинээр төрсөн хүүхэд | | хүн | 742 ^{↓4.2} | 604 ^{↓18.6} | 802 ^{↑32.8} | 756 ^{↓5.7} | 732 ^{↓3.2} |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | | хүн | 250 ^{↑11.6} | 22 963 ^{↑91.8*} | 270 ^{↓98.8} | 247 ^{↓8.5} | 267 ^{↑8.1} |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | | тоо | 347 ^{↓9.4} | 515 ^{↑48.4} | 645 ^{↑25.2} | 1 191 ^{↑84.7} | 1 155 ^{↓3.0} |
| Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт) | | хувь | 1.3 ^{↑0.8} | 2.0 ^{↑0.7} | 1.0 ^{↓1.0} | 1.4 ^{↓0.2} | 0.7 ^{↓0.7} |
| Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж) | Доллар (АНУ) | төгрөг | 2 850 ^{↑3.4} | 2 855 ^{↑0.2} | 3 514 ^{↑23.1} | 3 392 ^{↓3.5} | 3 459 ^{↑2.0} |
| | Юань (БНХАУ) | төгрөг | 441 ^{↑11.2} | 450 ^{↑2.0} | 513 ^{↑14.0} | 471 ^{↓8.2} | 476 ^{↓1.1} |
| | Рубль (ОХУ) | төгрөг | 38 ^{↓11.6} | 37 ^{↓2.6} | 48 ^{↑29.7} | 37 ^{↓22.9} | 38.0 ^{↑2.7} |
| Хан-Уул дүүргийн төсвийн орлого | | сая төгрөг | 21 517.4 ^{↑25.0} | 25 388.7 ^{↑18.0} | 46 756.1 ^{↑84.2} | 119 652.1 ^{↑2.5*} | 124 533.6 ^{↑4.1} |
| Хан-Уул дүүргийн төсвийн зарлага | | сая төгрөг | 10 760.4 ^{↓20.9} | 5 246.9 ^{↓51.2} | 7 479.9 ^{↑42.6} | 117 153.6 ^{↑15.7*} | 88 962.4 ^{↓24.1} |
| Агаарын дундаж температур | | °C | -13.4 | -12.4 | -17.0 | -13.3 | -18.8 |

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан



Эерэг хандлага, өөрчлөлт

Сөрөг хандлага, өөрчлөлт



ЭРҮҮЛ МЭНД, 2025 оны эхний 2 дугаар сард

ᠡᠷᠦᠭᠦᠯᠡᠮᠡᠨᠳᠡ



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2024 **247**

2025 **267**

8.1% ↑



Амаржсан эх



2024

745

2025

725

2.7% ↓

Шинэ төрсөн хүүхэд

2024

756

2025

732

3.2% ↓



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 267 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 20(8.1%) хүнээр нэмэгдэж, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1.4 продицимилээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 64.8 хувийг салхин цэцэг, 2.6 хувийг гар хөл, амны өвчин, 4.5 хувийг цусан суулга, 8.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.5 хувийг тэмбүү, 6.4 хувийг заг хүйтэн, 1.5 хувийг вируст гепатит, 7.1 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 2. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний II сард


| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 I-II | 2024 I-II | 2025 I-II | Өөрчлөлт 2025/2024 | |
|----------------------------|-----------------------------|-----------------|-----------------|-----------------|--------------------|--------------------|
| | | | | | тоо/нэгж | хувь |
| НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН | Бодит тоо 10000 хүнд | 270 13.3 | 247 12.2 | 267 10.8 | 20 -1.4 | 8.1 |
| Вируст гепатит | Бодит тоо 10000 хүнд | 1 - | 2 0.1 | 4 0.2 | 2 0.1 | 2.0 ¹ - |
| Цусан суулга | Бодит тоо 10000 хүнд | 16 0.8 | 20 1.0 | 12 0.5 | -8 -0.5 | -40.0 |
| Улаан эсэргэнэ | Бодит тоо 10000 хүнд | 4 0.2 | 18 0.9 | 3 0.1 | -15 -0.8 | -83.3 - |
| Сальмонеллэз | Бодит тоо 10000 хүнд | 0 - | 0 - | 3 0.1 | - - | - - |
| Салхин цэцэг | Бодит тоо 10000 хүнд | 203 10.0 | 122 6.0 | 173 7.0 | 51.0 1.0 | 41.8 |
| Гахайн хавдар | Бодит тоо 10000 хүнд | 0 - | 3 0.1 | 2 0.1 | -1 - | -33.4 |
| Ёлом | Бодит тоо 10000 хүнд | 2 0.1 | 3 0.1 | 2 0.1 | -1 - | -33.4 |
| Гар хөл, амны өвчин | Бодит тоо 10000 хүнд | 7 0.3 | 14 0.7 | 7 0.3 | -7 -0.4 | -50.0 |
| Тэмбүү | Бодит тоо 10000 хүнд | 9 0.4 | 18 0.9 | 12 0.5 | -6 -0.4 | -33.4 |
| Заг хүйтэн | Бодит тоо 10000 хүнд | 5 0.2 | 10 0.5 | 17 0.7 | 7 0.2 | 70.0 |
| Трихомониаз | Бодит тоо 10000 хүнд | 1 - | 2 0.1 | 0 - | - - | - - |
| Шинээр илэрсэн сүрьеэ | Бодит тоо 10000 хүнд | 20 1.0 | 32 1.6 | 23 0.9 | -9 -0.7 | -28.1 |
| Мөөгөнцөр | Бодит тоо 10000 хүнд | 0 - | 0 - | 0 - | - - | - - |
| Ковид 19 | Бодит тоо 10000 хүнд | 0 - | 0 - | 0 - | - - | - - |
| Бусад өвчлөл | Бодит тоо 10000 хүнд | 2 0.1 | 3 0.1 | 9 0.3 | 6 0.2 | 3.0 ¹ |

¹дахин

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



ЗУРАГ 2. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



2025 оны эхний 2 дугаар сард эхийн эндэгдэл гараагүй бол нялхсын эндэгдэл 2 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний II сард

| Үзүүлэлт | 2023 I-II | 2024 I-II | 2025 I-II | $\frac{2025}{2024}$ % |
|-----------------------------------|-----------|-----------|-----------|-----------------------|
| Амаржсан эхийн тоо | 800 | 745 | 725 | -2.7 |
| Амьд төрсөн хүүхэд | 802 | 756 | 732 | -3.2 |
| Төрөхийн улмаас эндсэн эх | 0 | 0 | 0 | - |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 5 | 10 | 8 | -20.0 |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 0 | 1 | 1 | - |

¹-дахин

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.


Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, 2025 оны эхний 2 сард

2025 оны эхний II сарын танилцуулга

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг




Тайлбар: ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД



ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД





НИЙГМИЙН ДААТГАЛ

2025 оны эхний 2 дугаар сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 98.8 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 14.3(16.9%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60.3 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2025 оны эхний II сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | | Биелэлт % | |
|--|-----------------|-----------------|-----------------|-----------------|--------------|-------------|
| | 2024 I-II | 2025 I-II | 2024 I-II | 2025 I-II | 2024 I-II | 2025 I-II |
| Нийт | 92 109.0 | 84 554.4 | 52 136.8 | 98 825.4 | -43.4 | 16.9 |
| Тэтгэврийн даатгалын сангийн орлого | 78 702.7 | 71 552.8 | 44 806.2 | 79 339.6 | -43.1 | 10.9 |
| Тэтгэмжийн сангийн орлого | 6 471.8 | 6 413.7 | 3 786.7 | 8 407.2 | -41.5 | 31.1 |
| ҮОМШӨ-ний даатгалын орлого | 4 411.7 | 4 169.3 | 421.7 | 8 079.7 | -90.4 | 93.8 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого | 2 453.8 | 2 448.6 | 3 053.2 | 2 998.9 | 24.4 | 22.5 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого | 69.0 | | 69.0 | | - | |


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 80.3 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.5 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 8.2 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 3.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 22076 хүнд 46.8 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3123 хүнд 4.1 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1015 хүнд 1.4 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1571 хүнд 4.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.


Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 1930 хүнд 924.6 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 653 хүнд 3.2 тэрбум төгрөгийг, 75 хүнд оршуулгын тэтгэмж 202.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 19 хүнд 317.9 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 39.3 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 28 хүнд 58.3 сая төгрөгийг, тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний бусад зардалд 4 хүнд 2.1 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1202 хүнд 3.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Мөн ажил олгогч даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээнд 1.4 сая төгрөг зарцуулсан байна.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 86.9 хувийг тэтгэврийн, 6.6 хувийг тэтгэмжийн, 0.6 хувийг ҮОМШӨ-ний, 5.8 хувийг ажилгүйдлийн зардал эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн 18.7 хувь нь нийгмийн халамжийн сан, 64.1 хувь нь хүүхдийн мөнгө, 10.2 хувь нь алдарт эхийн одонгийн тусламж, 3.5 хувь нь насны хишиг, 0.4 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 2.9 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.1 хувь нь хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, 0.1 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 19.8 (64.1%) тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгө буюу 99736 хүнд, 12 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 11170 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая төгрөг

| Үзүүлэлт | 2025.I-II | |
|---|-----------------|----------------|
| | Дүн | Хүний тоо |
| Нийгмийн халамжийн сангийн орлого | 30 973.7 | |
| Улсын төсвийн санхүүжилтийн орлого | 30 973.7 | |
| Нийгмийн халамжийн сан | 5 786.5 | |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 123.6 | |
| Алдарт эхийн одонгийн тусламж | 3 166.0 | |
| Насны хишиг | 1 097.9 | |
| Хүүхдийн мөнгө | 19 848.9 | |
| Цалинтай ээж хөтөлбөр | 899.8 | |
| Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж | 5.3 | |
| Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж | 5.1 | |
| Онцгой тохиолдолд олгох тэтгэмж | 2.4 | |
| Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 38.2 | |
| Зарлагын нийт дүн | 30 973.7 | 148 751 |
| Нийгмийн халамжийн сан | 5 786.5 | 9 093 |
| Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж | 1 028.5 | 11 170 |
| Алдарт эхийн одонгийн тусламж | 3 166.0 | 13 432 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 5.3 | 12 |
| Хүүхдийн мөнгө | 19 848.9 | 99 736 |
| Насны хишиг | 1 097.9 | 13 654 |
| Онцгой тохиолдолд олгох тэтгэмж | 2.4 | 2 |
| Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 38.2 | 1 652 |

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



ГЭМТ ХЭРЭГ, 2025 оны эхний 2 дугаар сар


Сүхбаатар
Сүхбаатар



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэл

2024 I-II | 2025 I-II
5 044 | **7 110** 41.0% ↑

Дүүргээр



Хан-Уул дүүрэгт гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

1 022



Гэмтсэн хүн

154



Нас барсан хүн

17



ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт 1055 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 371(54.2%) хэргээр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, 2025 оны эхний II сар


| Төрөл | Гэмт хэргийн тоо | | | Өөрчлөлт 2025/2024 | |
|--|------------------|------------|--------------|--------------------|------------------|
| | 2023 I-II | 2024 I-II | 2025 I-II | Тоо | Хувь |
| Дүүргийн дүн | 515 | 684 | 1 055 | 371 | 54.2 |
| Хүний амь | 6 | - | - | - | - |
| Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 15 | 14 | 12 | -2 | -14.3 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 117 | 106 | 131 | 25 | 23.6 |
| Хүчин | 5 | 12 | 10 | -1 | -16.7 |
| Хулгай | 108 | 124 | 190 | 66 | 53.2 |
| Малын хулгай | 1 | - | 3 | -3 | - |
| Дээрэм | 4 | 10 | 8 | -2 | -20.0 |
| Залилан | 167 | 258 | 464 | 206 | 79.8 |
| Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | - | - | 1 | -1 | - |
| Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих | 20 | 16 | 49 | 33 | 3.1 ¹ |
| Бусад | 72 | 144 | 187 | 43 | 29.9 |

¹ дахин

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 44.0 хувийг залилан, 12.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 18.0 хувийг хулгай, 4.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, 1.0 хувийг хүчин, 0.3 хувийг малын хулгай, 0.1 хувийг олон нийтийн амгалан тайван алдагдуулах, 0.8 хувийг дээрэм, 1.1 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 17.7 хувийг бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ

| Дүүрэг | Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг | | | Өөрчлөлт 2025/2024 | |
|-----------------------------|-----------------------------|--------------|--------------|--------------------|-------------|
| | 2023 I-II | 2024 I-II | 2025 I-II | Тоо | Хувь |
| Нийслэлийн дүн | 4 978 | 5 044 | 7 110 | 2 066 | 41.0 |
| Хан-Уул дүүргийн дүн | 649 | 684 | 1 055 | 371 | 54.2 |
| Үүнээс: Цагдаагийн хэлтсээр | | | | | |
| I хэлтэс | 406 | 390 | 603 | 213 | 54.6 |
| II хэлтэс | 243 | 294 | 452 | 158 | 53.7 |
| Нийслэлийн дүнд эзлэх хувь | 13.0 | 13.6 | 14.8 | 18.0 | 13.2 |

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувь 14.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй 1.2 нэгж хувиар өссөн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 57.2 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 8. ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр

| Хэлтэс | Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг | | Эмэгтэй хүн оролцсон | | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | |
|---------------|-------------------------------|-----------|----------------------|-----------|---------------------------------|-----------|
| | 2024 I-II | 2025 I-II | 2024 I-II | 2025 I-II | 2024 I-II | 2025 I-II |
| Нийт | 40 | 64 | 80 | 86 | 16 | 21 |
| Цагдаагийн I | 21 | 32 | 45 | 60 | 7 | 11 |
| Цагдаагийн II | 19 | 32 | 35 | 26 | 9 | 10 |

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2025 оны эхний 2 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас 21 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5 (31.3%) хэргээр өссөн байна. Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 1022 иргэн хохирсоны 486 (47.6%) нь эмэгтэйчүүд байсан бол 5 (0.5%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 8 (0.8%) нь 8-13 насны хүүхэд, 22 (2.2%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 154 хүн гэмтэж осолдон, 17 хүн нас барж, төр, ард иргэдэд 27888.1 сая төгрөгийн хохирол учруулсны 13374.3 (48.0%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2025 оны эхний 2 дугаар сард тус дүүргийн 15 дугаар хороонд 123 гэмт хэрэг гарч хамгийн өндөр, 22-р хороодын нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 5 гэмт хэрэг гарсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.


ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

| Хороод | Нийт дүн | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүчин | Хулгай | Үүнээс | | | Дээрэм | Залилан | Малын хулгай | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих | Бусад |
|-----------------|--------------|--|---|-----------|------------|------------|----------------------------------|-----------------|----------|------------|--------------|--|---|------------|
| | | | | | | ИӨХ | Авто тээврийн хэрэгсэл хулгайлах | Халаасны хулгай | | | | | | |
| Нийт дүн | 1 055 | 12 | 131 | 10 | 190 | 111 | 4 | 32 | 8 | 464 | 3 | 1 | 49 | 187 |
| 1-р хороо | 37 | | 2 | - | 7 | 5 | - | 2 | - | 16 | - | - | 1 | 11 |
| 2-р хороо | 33 | 1 | 3 | - | 6 | 5 | - | - | - | 17 | - | - | 1 | 5 |
| 3-р хороо | 92 | 1 | 11 | 1 | 14 | 11 | - | 2 | 2 | 42 | - | - | 6 | 15 |
| 4-р хороо | 28 | - | 3 | 1 | 6 | 4 | 1 | - | 1 | 9 | - | - | 4 | 4 |
| 5-р хороо | 14 | - | 1 | - | 2 | | - | - | - | 6 | - | - | - | 5 |
| 6-р хороо | 20 | - | 1 | - | 7 | 4 | 1 | 1 | - | 5 | - | - | 2 | 5 |
| 7-р хороо | 6 | | - | 2 | 3 | 3 | - | - | - | | - | - | 1 | - |
| 8-р хороо | 44 | 1 | 2 | - | 11 | 3 | 1 | - | - | 20 | - | - | 4 | 6 |
| 9-р хороо | 20 | - | 2 | - | 7 | 3 | - | - | - | 6 | - | - | 3 | 2 |
| 10-р хороо | 30 | - | 3 | 1 | 6 | 5 | - | - | - | 11 | - | - | 5 | 4 |
| 11-р хороо | 91 | 1 | 16 | 2 | 19 | 12 | - | 3 | 1 | 34 | | 1 | 1 | 16 |
| 12-р хороо | 13 | - | 1 | 1 | 3 | 3 | - | - | - | 4 | 1 | - | - | 3 |
| 13-р хороо | 10 | 2 | 2 | - | 1 | - | - | - | - | 3 | 1 | - | 1 | - |
| 14-р хороо | 22 | - | 5 | - | 7 | 3 | - | - | - | 4 | 1 | - | 2 | 3 |
| 15-р хороо | 123 | - | 22 | - | 25 | 12 | - | 10 | - | 49 | - | - | 2 | 25 |
| 16-р хороо | 20 | - | 4 | - | 9 | 5 | 1 | 1 | - | 4 | - | - | 2 | 1 |
| 17-р хороо | 39 | - | 3 | 1 | 8 | 5 | - | - | 1 | 22 | - | - | 2 | 2 |
| 18-р хороо | 50 | - | 6 | - | 6 | 3 | - | 1 | 1 | 27 | - | - | 2 | 8 |
| 19-р хороо | 48 | - | 7 | - | 2 | 1 | - | 1 | - | 23 | - | - | 1 | 15 |
| 20-р хороо | 85 | 1 | 11 | 1 | 6 | 4 | - | 2 | - | 49 | - | - | - | 17 |
| 21-р хороо | 72 | 1 | 7 | - | 10 | 6 | - | 3 | 2 | 37 | - | - | 3 | 12 |
| 22-р хороо | 5 | - | - | - | - | - | - | - | - | 3 | - | - | - | 2 |
| 23-р хороо | 51 | 1 | 7 | - | 5 | 3 | - | - | - | 33 | - | - | - | 5 |
| 24-р хороо | 72 | 3 | 9 | - | 13 | 6 | - | 5 | - | 27 | - | - | 5 | 15 |
| 25-р хороо | 30 | - | 3 | - | 7 | 5 | - | 1 | - | 13 | - | - | 1 | 6 |




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2025 оны эхний 2 дугаар сар, тэрбум төгрөг

Баян



Хан-Уул дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц






ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 124.5 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 71.9 (36.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2024 оноос 4.1 хувиар өссөн байна. Төсвийн нийт орлогын 60.2 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 39.8 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 74.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 22.6(23.2%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 49.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 49.3(49.9%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний II сард, сая.төгрөг

| Төсвийн орлого | | | Үүнээс: | | | | | | |
|----------------|-----------|---------------|-----------------|----------|-------------|---------------------|----------|-------------|-----------|
| Бүгд | ТБ % | Зөрүү сая.төг | Татварын орлого | | | Татварын бус орлого | | | |
| | | | Бүгд | ТБ % | Зөрүү сая.т | Бүгд | ТБ % | Зөрүү сая.т | |
| Дүн | 124 533.6 | -36.6 | -71 942.0 | 74 939.3 | -23.2 | 22 604.0 | 49 594.4 | -49.9 | -49 338.1 |

Орлогын албан татвар төлөвлөснөөс 19.2 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 1.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 1.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 10. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний II сард, сая.төгрөг

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | |
|--|------------------|------------------|------------------|------------------|
| | | | ТБ хувь | Зөрүү |
| Орон нутгийн орлого | 196 475.7 | 124 533.6 | -36.6 | -71 942.0 |
| 1.Татварын орлогын дүн | 97 543.3 | 74 939.3 | -23.2 | -22 604.0 |
| 1.1 Орлогын албан татвар | 87 141.4 | 67 911.0 | -22.1 | -19 230.4 |
| Хувь хүний орлогын албан татвар | 87 141.4 | 67 911.0 | -22.1 | -19 230.4 |
| 1.2 Хөрөнгийн албан татвар | 3 016.0 | 1 528.9 | -49.3 | -1 487.1 |
| 1.3 Бусад татвар,төлбөр, хураамж | 7 385.8 | 5 499.4 | -25.5 | -1 886.4 |
| 1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3 377.5 | 2 128.9 | -37.0 | -1 248.6 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 2 500.0 | 1 786.0 | -28.6 | -714.0 |
| Ашигт малтмал ашигласны төлбөр | 44.2 | 2.0 | -95.5 | -42.2 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 833.3 | 340.9 | -59.1 | -492.4 |
| 1.3.2 Газрын төлбөр | 4 000.0 | 3 364.7 | -15.9 | -635.3 |
| 1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 8.3 | 5.8 | -30.1 | -2.5 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 8.3 | 5.8 | -30.1 | -2.5 |
| 2.Татварын бус орлогын дүн | 98 932.4 | 49 594.4 | -49.9 | -49 338.0 |
| 2.1 Нийтлэг татварын бус орлого | 715.6 | 1 816.1 | 2.5 ¹ | 1 100.5 |
| Торгуулийн орлого | 666.7 | 1 780.5 | 2.7 ¹ | 1 113.8 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого* | 42.1 | 35.6 | -15.4 | -6.5 |
| Бусад орлого | 6.9 | 0.1 | -98.6 | -6.8 |
| 2.2 Тусламжийн орлого | 98 216.8 | 47 778.2 | -51.4 | -50 438.6 |
| 2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |


¹-дахин

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

2025 оны эхний 2 дугаар сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 88.9 (80.0%) тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 22.2 (20.0%) тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 2.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 97.3 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний II сард, сая төгрөг

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | |
|--|------------------|-----------------|--------------|-----------------|
| | | | ТБ хувь | Зөрүү |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 111 176.0 | 88 962.4 | -20.0 | -22214.0 |
| 1. Урсгал зарлага | 88 528.2 | 85 474.6 | -3.4 | -3 053.6 |
| 1.1 Бараа, үйлчилгээний зардал | 20 890.7 | 12 554.8 | -39.9 | -8 335.9 |
| Цалин хөлс | 3 110.7 | 2 166.3 | -30.4 | -944.4 |
| Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 389.7 | 242.5 | -37.8 | -147.2 |
| Бараа, үйлчилгээний бусад зардал | 17 390.3 | 10 146.0 | -41.7 | -7 244.3 |
| 1.2 Татаас ба урсгал шилжүүлэг | 67 637.5 | 72 919.8 | 7.8 | 5 282.3 |
| Татаас | - | - | - | - |
| Урсгал шилжүүлэг | 67 637.5 | 72 919.8 | 7.8 | 5 282.3 |
| 2. Хөрөнгийн зардал | 25 647.8 | 3 487.8 | -86.4 | -22 160.0 |
| Барилга байгууламж | 11 429.4 | 1 560.0 | -86.4 | -9 869.4 |
| Тоног төхөөрөмж | 1 500.0 | - | - | -1 500.0 |
| Бусад хөрөнгө | 12 718.4 | 1 927.8 | -84.8 | -10 791.0 |

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд үлдэгдэлгүй байсан бол шинээр өглөг үүсээгүй байна.

ХҮСНЭГТ 12. ӨГЛӨГ, 2025 оны эхний II сард, сая төгрөг

| | 2-р сарын эхний үлдэгдэл | Шинээр үүссэн өглөг | Тухайн сард төлөгдсөн | 2-р сарын эцсийн үлдэгдэл |
|----------|-----------------------------|------------------------|--------------------------|------------------------------|
| Нийт дүн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2025 оны 02 дугаар сард)

МОНГОЛЫН
СТАТИСТИКА
УЛСЫН
ТӨСӨВ

Ерөнхий индекс

10.3

Хүнсний бараа, согтууруулах
бус ундаа

8.7

Согтууруулах ундаа, тамхи,
мансууруулах бодис

5.0

Хувцас, бөс бараа, гутал

10.1

Орон сууц, ус, цахилгаан,
хийн болон бусад түлш

25.4

Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа

9.2

Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ

3.2

Тээвэр

7.2

Холбооны хэрэгсэл,
шуудангийн үйлчилгээ

1.2

Амралт, чөлөөт цаг,
соёлын бараа, үйлчилгээ

6.6

Боловсролын үйлчилгээ

20.4

Зочид буудал, нийтийн хоол,
дотуур байрны үйлчилгээ

11.5

Даатгал, Санхүүгийн үйлчилгээ

4.3

Бусад бараа, үйлчилгээ

11.5

0 5 10 15 20 25 30




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өслөө.

2025 оны 2 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 2.9 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 1.8 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 02 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 4.0 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 1.7 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 0.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 2.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.4 хувь, тээвэр бүлгийн үнэ 4.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 4.0 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ 4.3 хувиар, бусад бараа үйлчилгээний үнэ 3.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 13 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2024-II 2023-II | 2025-II 2024-II | 2025-II 2024-XII | 2025-II 2025-I |
|---|--------------------|--------------------|---------------------|-------------------|
| Ерөнхий индекс | 7.2 | 10.3 | 2.9 | 1.8 |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 10.0 | 8.7 | 4.0 | 2.0 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 3.9 | 5.0 | 1.7 | 1.3 |
| Хувцас, бөс бараа, гутал | 5.3 | 10.1 | 0.8 | 0.4 |
